

2023 оны 02 сарын 03-ны өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Эрсдэлийн удирдлагын бодлогыг шинэчлэн батлах тухай

Говь ХК-ийн “Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийг хангах хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах, засаглалын тогтолцоог бэхжүүлэх, эрсдэлийн удирдлагыг оновчтой бөгөөд үр дүнтэй хэрэгжүүлэх зорилтын хүрээнд Эрсдэлийн удирдлагын бодлогыг шинэчлэн батлах тухай асуудлыг хэлэлцэн, Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13 дахь заалтыг үндэслэн Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь**:

Нэг. Говь ХК-ийн “Эрсдэлийн удирдлагын бодлого”-ыг Хавсралт-1 ёсоор баталсугай.

Хоёр. Энэхүү бодлогын хэрэгжилтийг ханган, үйл ажиллагаандaa мөрдлөг болгон ажиллахыг компанийн эрсдэлийн удирдлагын баг, Гүйцэтгэх захирал /Ц.Баатарсайхан/-д үүрэг болгосугай.



Д.ГЭРЭЛМАА

“ГОВЬ”
ХУВЬЦААТ КОМПАНИ

Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2023 оны 02 сарын 03-ний өдрийн хурлын 04-р
тогтоолын 17.. дүгээр хавсралт





ЗӨВЛӨЛ
Дугаар:
НН2998 № 2076357
Б-ТУЗ-02-03

| | | |
|-----------------------------------|------------------------------|--|
| GOBI MONGOLIAN CASHMERE | ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГО | |
|-----------------------------------|------------------------------|--|

БАРИМТ БИЧГИЙН НЭР:

ГОВЬ ХК-ИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГО

| | | | |
|---|---|-----------------------------|----|
| БАРИМТ БИЧГИЙН ХАРИУЦАГЧ | ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ХЭЛТЭС | | |
| БАРИМТ БИЧГИЙН ХАМРАХ ХҮРЭЭ | ТУЗ, ГОВЬ ХК-ИЙН НИЙТ АЖИЛТАН, ОХИН КОМПАНИЙН АЖИЛТNUУД, ХЭРЭГЛЭГЧ, ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД, ГЭРЭЭТ КОМПАНИ, ХАНГАН НИЙЛҮҮЛЭГЧИД, ГЭРЭЭТ АЖИЛТNUУД | | |
| БАТЛАГДСАН ОГНОО | 2023.02.03 | | |
| БАРИМТ БИЧГИЙН НУУЦЛАЛЫН ЗЭРЭГЛЭЛ | НЭЭЛТТЭЙ | БАРИМТ БИЧГИЙН ТҮВШИН | T1 |

| | АЛБАН ТУШААЛ | НЭР | ГАРЫН ҮСЭГ |
|-----------|---------------------------------|----------------|---|
| БАТАЛСАН: | ТУЗ-ИЙН ДАРГА | Д.ГЭРЭЛМАА |  |
| ХЯНАСАН: | ТУЗ-ИЙН ГИШҮҮН | Ц.БААТАРСАЙХАН |  |
| | ТУЗ-ИЙН ГИШҮҮН | М.БАЯР |  |
| | ТУЗ-ИЙН ГИШҮҮН | Ж.ОЮУНЧИМЭГ |  |
| | ТУЗ-ИЙН ГИШҮҮН | А.ЖАРГАЛМАА |  |
| | ТУЗ-ИЙН ГИШҮҮН | Д.ХУЛАН |  |
| | ТУЗ-ИЙН ГИШҮҮН | Д.ХҮРЭЛБААТАР |  |
| | ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА | М.СЭЛЭНГЭ |  |

| | | |
|-----------------------------------|---|------------------------|
| GOBI MONGOLIAN CASHMERE | ГОВЬ ХК-ИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГО | Дугаар: Б-ТУЗ-02-03 |
|-----------------------------------|---|------------------------|

| | | | |
|--|--|----------------------|---|
| | ТЭРГҮҮН ДЭД ЗАХИРАЛ /ДИЗАЙН, ҮЙЛДВЭРЛЭЛ, ДЭМЖИХ/ ХУУЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА | Ц. ОРГИЛБОЛД |  |
| | ТХХ-ИЙН ДАРГА | Ц. ЦАСЧИХЭР | |
| | БОЛОВСРУУЛСАН: | ЭРСДЭЛИЙН МЕНЕЖЕР | |
| | | Э. ИВГЭЭЛ |  |
| | | Т. ЭНХЦАЦРАЛ |  |

Улаанбаатар хот

2023 он

| | | |
|---|---|-------------------------------|
|  | ГОВЬ ХК-ИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГО | Дугаар: Б-ТУЗ-02-03 |
|---|---|-------------------------------|

| Баримт бичгийн өөрчлөлтийн бүртгэл | | | |
|---|------------------------------------|---|--|
| Хувилбарын дугаар | Хүчин төгөлдөр болсон огноо | Өөрчлөлт оруулж, боловсруулсан албан тушаалтан | Өөрчлөлтийн утга (баримт бичигт ямар өөрчлөлт орсныг товч тайлбарлана) |
| 01 | 2018.12.21 | Эрсдэлийн менежер С.Насанжаргал | Баримт бичгийн анхны хувилбар |
| 02 | 2020.06.22 | Эрсдэлийн менежер С.Насанжаргал | Баримт бичгийн шинэчилсэн хувилбар |
| 03 | 2023.02.03 | Эрсдэлийн менежер Т.Энхцацрал | ЭУБодлогын иш татсан баримт бичгүүд, зорилго, хамрах хүрээ, нэр томьёоны тайлбар, эрсдэлийн удирдлагын зарчим, эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэм хэмжээ, эрсдэлийн тогтолцооны мониторинг, эрсдэлийн удирдлагын үүрэг хариуцлага, хариуцлагын заалтуудад өөрчлөлт оруулсан. |

| Баримт бичгийн төлөв | | |
|---|-------------------------------|----------------------|
| Эх хувь | Албан хэрэгцээний хувь | Хүчингүй хувь |
|  | | |

| ИШ ТАТСАН БАРИМТ БИЧГҮҮД | | |
|---------------------------------|--|--------------------------|
| № | Баримт бичгийн нэр | Бүртгэлийн дугаар |
| 1 | Говь ХК-ийн Засаглалын бодлого | Б-ТУЗ-14-01 |
| 2 | Говь ХК-ийн Бизнесийн тасралтгүй үйл ажиллагааны бодлого | Б-ТХХ-08-01 |
| 3 | Говь ХК-ийн Тогтвортой хөгжлийн бодлого | Б-ТХХ-01-01 |
| 4 | Говь ХК-ийн Комплаенсийн бодлого | Б-ТХХ-07-01 |
| 5 | Говь ХК-ийн Дотоод хяналтын бодлого | Б-ТУЗ-03-01 |

| | | |
|---|---|------------------------|
|  | ГОВЬ ХК-ИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГО | Дугаар: Б-ТУЗ-02-03 |
|---|---|------------------------|

АГУУЛГА

| | |
|---|-----------|
| 1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ..... | 6 |
| 1.1 Зорилго | 6 |
| 1.2 Хамрах хүрээ..... | 6 |
| 1.3 Нэр томъёоны тайлбар..... | 6 |
| 2. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ЗАРЧИМ..... | 7 |
| 2.1 Үнэт зүйлийг бий болгох ба хамгаалах | 7 |
| 2.2 Засаглалын зохистой бүтцийг хэрэгжүүлэх..... | 7 |
| 2.3 Байгууллагын үйл явцын салшгүй хэсэг байх | 7 |
| 2.4 Шийдвэр гаргалтын нэг хэсэг байх: | 8 |
| 2.5 Ил тод ба оролцоог хангасан байх: | 8 |
| 2.6 Эрсдэлийн соёлыг төлөвшүүлэх:..... | 8 |
| 2.7 Тасралтгүй сайжруулах: | 8 |
| 3. ЭРСДЭЛИЙН БОДЛОГЫН БҮРДЭЛ ХЭСЭГ..... | 8 |
| 3.1 Ерөнхий шаардлага..... | 8 |
| 3.2 Засаглал, бүтэц зохион байгуулалт..... | 8 |
| 3.3 Эрсдэлийн хүлээн зөвшөөрөгдөх хэмжээ..... | 9 |
| 3.4 Эрсдэлийн соёл, соёлын элемент..... | 9 |
| 3.5 Эрсдэлийн тогтолцооны мониторинг | 10 |
| 4. МАНЛАЙЛАЛ БА ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА..... | 10 |
| 4.1 Эрсдэлийн бодлогын үүрэг хариуцлага | 10 |
| 4.2 Төлөөлөн удирдах зөвлөлийн эрх, үүрэг | 11 |
| 4.3 Эрсдэл, аудитын хорооны эрх, үүрэг | 11 |

| | | |
|---|---|------------------------|
|  | ГОВЬ ХК-ИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГО | Дугаар: Б-ТУЗ-02-03 |
|---|---|------------------------|

| | | |
|-----|---|----|
| 4.4 | Гүйцэтгэх захирлын эрх, үүрэг | 11 |
| 4.5 | Эрсдэлийн удирдлагын багийн эрх, үүрэг | 12 |
| 4.6 | Нэгжийн удирдлагын эрх, үүрэг..... | 12 |
| 5. | ХАРИУЦЛАГА..... | 13 |
| 5.1 | Ажилтан, эрх бүхий албан тушаалтны хариуцлага..... | 13 |
| 6. | ХАВСРАЛТ | 14 |
| 6.1 | Хавсралт №1 Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх бүтэц..... | 14 |
| 6.2 | Хавсралт №2 Эрсдэлийн түвшин тогтоох матриц..... | 15 |
| 6.3 | Хавсралт №3 Эрсдэлийг удирдах шийдвэр | 15 |

| | | |
|---|---|-------------------------------|
|  | ГОВЬ ХК-ИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГО | Дугаар: Б-ТУЗ-02-03 |
|---|---|-------------------------------|

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Зорилго

1.1.1 Энэхүү бодлогын зорилго нь “Говь” ХК-ийн ерөнхий үзэл баримтлал, чиглэлд нийцтэй эрсдэлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлэх, оролцогчдын эрх үүргийг тодорхойлох, эрсдэлийн удирдлагыг амжилттай хэрэгжүүлэх, хэрэгжилтэд мониторинг хийж, тасралтгүй сайжруулахад оршино. Удирдлагын баг болон нэгжүүдийн ажиллах үндсэн зарчим, эрх үүрэг, хариуцлагыг тодорхойлно.

1.2 Хамрах хүрээ

- 1.2.1 Компанийн хэмжээнд эрсдэлийн удирдлагын бүтцийг гаргах, хэрэгжүүлэх, хянах, дүн шинжилгээ хийх, байнга сайжруулахад чиглэсэн үндсэн ба зохион байгуулалтын арга хэмжээнүүдийн цогц байна.
- 1.2.2 Энэхүү бодлого нь компанийн Төлөөлөн удирдах зөвлөл, Эрсдэл, аудитын хороо, Эрсдэлийн удирдлагын багийн гишүүд, компанийн нэгжийн удирдлага, нийт ажилтнууд болон гэрээт байгууллагуудад хамаарна.

1.3 Нэр томъёоны тайлбар

- 1.3.1 Уг бодлогын хүрээнд дараах нэр томъёог ашиглана.
 - 1.3.1.1 **Эрсдэл:** Байгууллага зорилго, зорилтдоо хүрэхэд учрах, зорилтыг тодорхой бус болгож байгаа үр нэлөө юм. Тодорхой бус байдал гэж аливаа тохиолдол, түүний үр нэлөө болон тохиолдох магадлал, хурд, хэврэг байдлын талаарх ойлголт, мэдээлэл зарим нэг талаар хангалтгүй байх;
 - 1.3.1.2 **Эрсдэлийн удирдлага:** Байгууллагын бүхий л үе шатанд эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, эрсдэлд тохирох хариу арга хэмжээ авах, мэдээлэх тасралтгүй үйл ажиллагаа;
 - 1.3.1.3 **Эрсдэл хариуцагч:** Эрсдэлийг хариуцаж бууруулах үүрэгтэй эрх мэдэл, үүрэг хариуцлага бүхий нэгжийн удирдлага болон ажилтнууд;
 - 1.3.1.4 **Эрсдэлийн хүлээн зөвшөөрөгдөх хэмжээ:** ТУЗ-ийн түвшинд хүлээж буй, хүлээн зөвшөөрөгдөх эрсдэлийн хэмжээ;
 - 1.3.1.5 **Эрсдэлийг хэмжих индикатор:** ТУЗ-ийн Эрсдэлийг хэмжих индикатор буюу эрсдэлийг хэмжих үзүүлэлт;
 - 1.3.1.6 **Нэгж:** Компанийн газар, үйлдвэр, хэлтэс, алба, нэгж;
 - 1.3.1.7 **ТУЗ:** Төлөөлөн удирдах зөвлөл;
 - 1.3.1.8 **ЭАХ:** Эрсдэл, аудитын хороо;

| | | |
|---|---|------------------------|
|  | ГОВЬ ХК-ИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГО | Дугаар: Б-ТУЗ-02-03 |
|---|---|------------------------|

- 1.3.1.9 **ГЗ:** Гүйцэтгэх захирал;
- 1.3.1.10 **ЭУБ:** Эрсдэлийн удирдлагын баг;
- 1.3.1.11 **ЭМ:** Эрсдэлийн менежер;
- 1.3.1.12 **НУ:** Компанийн нэгжийн удирдлага;
- 1.3.1.13 Эрсдэлийг эх үүсвэрээс нь хамааруулан дараах ангиллаар тодорхойлон авч үзнэ:
- **Стратегийн эрсдэл:** Гадаад болон дотоод хүчин зүйлсийн нөлөөллөөс шалтгаалан стратеги зорилго, зорилтыг хангахад учрах эрсдэл;
 - **Санхүүгийн эрсдэл:** Гадаад болон дотоод хүчин зүйлсийн нөлөөллөөс шалтгаалан компанийн санхүүгийн үйл ажиллагаанд учрах эрсдэл;
 - **Үйл ажиллагааны эрсдэл:** Дотоод хүчин зүйлсийн нөлөөллөөс шалтгаалан компанийн үйл ажиллагаанд учрах эрсдэл;
 - **Нийцлийн эрсдэл:** Гадаад болон дотоод хүчин зүйлсийн нөлөөллөөс шалтгаалан үл нийцэл учрах эрсдэл;

2. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ЗАРЧИМ

2.1 Үнэт зүйлийг бий болгох ба хамгаалах

2.1.1 Үнэт зүйл нь байгууллагын хувийн шинж чанар, амин сүнс бөгөөд ажилтнууд аливаа үйлдэл хийхдээ харгалзан үзэх тулгуур үзэл баримтлал юм. Тиймээс тулгуур үзэл баримтлалыг бий болгох, тасралтгүй хамгаалах зарчмыг баримтална.

2.2 Засаглалын зохистой бүтцийг хэрэгжүүлэх

2.2.1 Эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь засаглалын түвшинд бодлогоор чиглүүлэх, хэрэгжүүлэлтийн түвшинд удирдлагаар хангах зохистойгоор бүрдүүлнэ.

2.3 Байгууллагын үйл явцын салшгүй хэсэг байх

2.3.1 Байгууллагын эрхэм зорилго, алсын хараа, стратеги төлөвлөлт, өөрчлөлтийн удирдлагын үйл явцыг багтаасан байгууллагын бүх үйл явцын салшгүй хэсэг байна.

| | | |
|---|---|-------------------------------|
|  | ГОВЬ ХК-ИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГО | Дугаар: Б-ТУЗ-02-03 |
|---|---|-------------------------------|

2.4 Шийдвэр гаргалтын нэг хэсэг байх:

- 2.4.1 Удирдлагын аливаа шийдвэр гаргалтад дэмжлэг болох мэдээллээр хангах, шийдвэрийн хувилбаруудад эрсдэлийн дүгнэлт өгч, түвшинг тогтоон, олон хувилбаруудаас сонголт хийхэд тусална.

2.5 Ил тод ба оролцоог хангасан байх:

- 2.5.1 Байгууллагын бүх оролцогч талуудын саналыг эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаандaa тусгах, тэднээс мэдээлэл авах, саналаа илэрхийлэх боломжуудыг тодорхойлж, эргэх холбоотой ажиллах ба байгууллагын удирдлагуудыг тухай бүр мэдээллээр тасралтгүй хангах системийг бүрдүүлэн ажиллана.

2.6 Эрсдэлийн соёлыг төлөвшүүлэх:

- 2.6.1 Байгууллагын алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлсэд тулгуурласан шийдвэр гаргалт, харилцааны зарчмыг баримтлан байгууллага даяарх оролцоог хангасан соёлыг төлөвшүүлнэ.

2.7 Тасралтгүй сайжруулах:

- 2.7.1 Компанийн бүх үйл ажиллагаандaa эрсдэлийн удирдлагыг бүрэн хэрэгжүүлж, бодлого, журмын хэрэгжилтэд тасралтгүй үнэлгээ хийн, тухай бүр тогтмол сайжруулах, тасралтгүй үргэлжлэх процесс байна.

3. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН БҮРДЭЛ ХЭСЭГ

3.1 Ерөнхий шаардлага

- 3.1.1 Эрсдэлийн бодлогын бүрэлдэхүүн хэсэгт доорх зүйлсийг багтаах бөгөөд тухайн үеийн стратегийн зорилго, эрсдэлийн /өмнөх/ мониторингийн дүгнэлт, оролцогч талуудаас ирсэн саналд үндэслэн тодорхой хугацаанд ТУЗ эрсдэлийн бодлогыг хэлэлцэж, батална.

3.2 Засаглал, бүтэц зохион байгуулалт

- 3.2.1 Эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь засаглал, хэрэгжүүлэлт гэсэн үндсэн хоёр түвшнээс бүрдэнэ.
- 3.2.2 Компанид эрсдэлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлэгч нь ТУЗ, түүний дэргэдэх Эрсдэл, аудитын хороо байна.
- 3.2.3 Компанид эрсдэлийн бодлогыг хэрэгжүүлэгч нь эрсдэлийн удирдлагын баг байх бөгөөд Гүйцэтгэх захирал багийн бүрэлдэхүүнийг "Эрсдэлийн удирдлагын бодлого"-д нийцүүлэн томилно.

| | | |
|---|---|-------------------------------|
|  | ГОВЬ ХК-ИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГО | Дугаар: Б-ТУЗ-02-03 |
|---|---|-------------------------------|

3.2.4 Эрсдэлийн менежер нь эрсдэлийн удирдлагын багийн гишүүн бөгөөд орон тооны ажилтан байна.

3.2.5 Нэгжийн удирдлагууд нь эрсдэлийг хариуцагч байна.

3.3 Эрсдэлийн хүлээн зөвшөөрөгдөх хэмжээ

3.3.1 Компанийн үйл ажиллагааг явуулахад хүлээн зөвшөөрөгдөх эрсдэлийн түвшинг илэрхийлэх бөгөөд жил бүр ЭАХ-оос эргэн хянаж, шинэчилнэ.

3.3.2 Эрсдэлийн хүлээн зөвшөөрөгдөх хэмжээг эрсдэлийн төрлөөр, хүлээн зөвшөөрөгдөх эрсдэлийн түвшнийг дулааны матрицын аргаар (чанар) болон эрсдэлийг хэмжих индикатор үзүүлэлтээр (тоон) тодорхойлно.

Хүснэгт 1 Эрсдэлийн хүлээн зөвшөөгдөх хэм хэмжээ

| | |
|------------------------|---|
| Стратегийн эрсдэл | Компанийн хэрэгжүүлэх санаачилгууд үр ашиггүй, бүтээмжгүй болох эрсдэлийг дунд хэмжээнд хүлээн зөвшөөрнө. |
| Нийцлийн эрсдэл | Компанийн зайлшгүй дагаж мөрдөх, хууль эрхзүйн болон компанийн дүрэм, журам, заавар, шаардлагуудыг санаатайгаар, зориудаар зөрчихийг хатуу хориглоно. Үүнээс үүдэх эрсдэлийг ул хүлээн зөвшөөрнө . |
| Санхүүгийн эрсдэл | Компанийн санхүүгийн тогтвортгуй байдалтай холбоотой эрсдэлийг дунд хэмжээнд хүлээн зөвшөөрнө. |
| Үйл ажиллагааны эрсдэл | Компанийн үйл ажиллагааны эрсдэлийг нь бага хэмжээнд хүлээн зөвшөөрнө. Мэдээллийн технологийн эрсдэлийг маш бага хэмжээнд хүлээн зөвшөөрнө. Ёс зүйгээс үүдэн гарах эрсдэлийг маш бага хэмжээнд хүлээн зөвшөөрнө. Санаатайгаар болон зориудаар ёс зүйн дүрмийг зөрчсөн бол компани ямар ч тохиолдолд ул хүлээн зөвшөөрнө . |
| Давагдашгүй эрсдэл | Давагдашгүй хүчин зүйлээс үүсэх эрсдэлийг дунд хэмжээнд хэмжээнд хүлээн зөвшөөрнө. |

3.4 Эрсдэлийн соёл, соёлын элемент

3.4.1 Компанийн эрсдэлийн соёл нь ажилтан бүр эрсдэлийн удирдлагын талаар зөв зохистой мэдлэг, оролцоотой байхыг илэрхийлнэ.

3.4.2 Компанийн эрсдэлийн соёлын элемент нь дараах зүйлсээс бүрдэнэ. Үүнд:

3.4.2.1 Дээд удирдлагын хандлага;

| | | |
|---|---|-------------------------------|
|  | ГОВЬ ХК-ИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГО | Дугаар: Б-ТУЗ-02-03 |
|---|---|-------------------------------|

- 3.4.2.2 Засаглал;
- 3.4.2.3 Хариуцлага;
- 3.4.2.4 Шийдвэр гаргалт.

3.5 Эрсдэлийн тогтолцооны мониторинг

- 3.5.1 Эрсдэлийн бодлого, журам, түүний хэрэгжилтэд жил бүр мониторинг хийж, эрсдэлийн удирдлагын процессын тасралтгүй байдлыг хангах, сайжруулах, ЭҮ-н тогтолцоо болон ЭҮ-н соёлыг дээшлүүлэхэд чиглэнэ.
- 3.5.2 Мониторингийг урьдчилсан болон гүйцэтгэлийн дараах гэсэн 2 шатаар хийнэ.
Үүнд:
 - 3.5.2.1 Урьдчилсан мониторингийг хийхдээ Эрсдэл аудитын хорооны гишүүд, Эрсдэлийн удирдлагын баг болон компанийн нийт ажилтнууд болон нэгжийн удирдлагуудаас санал аван, үнэлэх байдлаар хийнэ.
 - 3.5.2.2 Гүйцэтгэлийн дараах мониторингийг дотоод аудитын хэлтсээс бие даасан хараат бусаар, 3-р шугамын хяналтыг хэрэгжүүлэх буюу аудит хийх байдлаар гүйцэтгэнэ.

4. МАНЛАЙЛАЛ БА ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

4.1 Эрсдэлийн бодлогын үүрэг хариуцлага

Хүснэгт 2: Эрсдэлийн бодлогын үүрэг, хариуцлагын матриц

| Процесс | ТУЗ | ЭАХ | ГЗ | ЭУБ | НУ | ЭМ | Оролцогч талууд |
|--|-----|------|------|------|------|------|-----------------|
| <i>/Х-хариуцах, Г-гүйцэтгэх, З-зөвлөлдөн хамтран ажиллах, М-мэдээлэл авах/</i> | | | | | | | |
| Эрсдэлийн бодлогыг боловсруулан батлах | X | 3, M | 3, M | Г | 3, M | Г | M |
| Эрсдэлийн бодлогыг оролцогч талуудад түгээх мэдээллээр хангах | M | M | 3, M | Г | Г | X, Г | M |
| Эрсдэлийн бодлогыг үйл ажиллагаандaa хэрэгжүүлэх | M | M | Г | X, Г | Г | Г, З | M |
| Эрсдэлийн бодлогыг хэрэгжүүлэхэд арга зүйгээр хангах | M | Г | 3, M | X, Г | 3, M | Г, З | M |

| | | |
|---|---|-------------------------------|
|  | ГОВЬ ХК-ИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГО | Дугаар: Б-ТУЗ-02-03 |
|---|---|-------------------------------|

| | | | | | | | |
|---|---------|------|------|------|------|---|---|
| Эрсдэлийн бодлогын хэрэгжилтэд хяналт тавих, сайжруулах | Г, М | Г, З | 3, М | Х, Г | 3, М | Г | М |
| Шаардлагатай тохиолдолд шинэчлэх | Г, З, М | 3, М | 3, М | Х, Г | 3, М | Г | М |

4.2 Төлөөлөн удирдах зөвлөлийн эрх, үүрэг

- 4.2.1 Эрсдэлийн удирдлагын бодлого, журам, тогтолцоо, соёлын хөтөлбөрийн бүх түвшинд санал оруулж, сайжруулах зөвлөмж өгөх, эрсдэлийн удирдлагын бодлогын хэрэгжилтийг хянах эрхтэй.
- 4.2.2 Компанийн стратегийн зорилго, зорилтоо хэрэгжүүлэхэд нь дэмжлэг болохуйц эрсдэлийн удирдлагын тогтолцоог бий болгох, түүний дотор байгууллагын хэмжээнд эрсдэлийн удирдлагыг нэгтгэх үүрэгтэй.
- 4.2.3 Эрсдэлийн бодлогын баримт бичгийг батлах үүрэгтэй. Эрсдэлийн удирдлагын бодлогыг шаардлагатай тохиолдолд шинэчлэн хавсралтаар батална.

4.3 Эрсдэл, аудитын хорооны эрх, үүрэг

- 4.3.1 Эрсдэлийн удирдлагын бодлого, журам, тогтолцоо, соёлын хөтөлбөрийн бүх түвшинд санал оруулж, сайжруулах зөвлөмж өгөх эрхтэй.
- 4.3.2 ТУЗ-аас баталсан эрсдэлийн удирдлагын бодлогын баримт бичиг, түүний бүрдэл хэсгүүдийг шаардлагатай тохиолдолд хэлэлцэн, сайжруулж, ТУЗ-д санал оруулах эрхтэй.
- 4.3.3 Компанийн стратегийн зорилго, зорилтоо хэрэгжүүлэхэд нь дэмжлэг болохуйц эрсдэлийн удирдлагын тогтолцоог бий болгох, түүний дотор байгууллагын хэмжээнд эрсдэлийн удирдлагын бодлогын хэрэгжилтийг үнэлэн, тасралтгүй сайжруулах бөгөөд хөндлөнгийн хяналт тавих буюу 3-р шугамын хяналт тавих үүрэгтэй.
- 4.3.4 Хараат бус, бие даасан байдлаар аудит явуулах замаар эрсдэлд суурисан аргачлалыг ашиглаж, ТУЗ-д хараат бус баталгаажуулалтыг гаргаж өгөх үүрэгтэй.
- 4.3.5 Хамгаалалтын 1-р шугамын буюу нэгжийн удирдлагын болон хамгаалалтын 2-р шугамын буюу Эрсдэлийн удирдлагын багийн хяналтын үр дүнтэй байдалд хараат бус үнэлэлт, дүгнэлт өгөх үүрэгтэй.

4.4 Гүйцэтгэх захирлын эрх, үүрэг

- 4.2.1 Эрсдэлийн удирдлагын бодлого, журам, тогтолцоо, соёлын хөтөлбөрийн бүх түвшинд санал оруулж, сайжруулах зөвлөмж өгөх эрхтэй.

| | | |
|---|---|-------------------------------|
|  | ГОВЬ ХК-ИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГО | Дугаар: Б-ТУЗ-02-03 |
|---|---|-------------------------------|

4.2.2 Эрсдэлийн удирдлагын зохистой бүтцийг бүрдүүлж, Засаглалын бодлого, Тасралтгүй үйл ажиллагааны бодлого, Тогтвортой хөгжлийн бодлого, Комплаенсын бодлогод тус тус нийцүүлэн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх үүрэгтэй.

4.5 Эрсдэлийн удирдлагын багийн эрх, үүрэг

- 4.5.1 Эрсдэлийн бодлогын баримт бичгийг шаардлагатай тохиолдолд сайжруулан боловсруулж, Эрсдэл аудитын хороонд санал оруулах эрхтэй.
- 4.5.2 Батлагдсан эрсдэлийн бодлого, журам, соёлын хөтөлбөрийн хүрээнд компанийн эрсдэлийн удирдлагын бодлогын хэрэгжилтийг хангуулах үүрэгтэй.
- 4.5.3 Компанид эрсдэлийн удирдлагын үйл явцыг хэрэгжүүлэхдээ журам батлах бөгөөд уг журмын хэрэгжилтийг хангуулах үүрэгтэй.
- 4.5.4 Эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны хэрэгжилтийг улирал бүр Эрсдэл аудитын хороонд тайлгнах үүрэгтэй.
- 4.5.5 Эрсдэлийн менежер нь ТУЗ, Эрсдэл аудитын хороо, эрсдэлийн удирдлагын багийн санал, зөвлөмжийг хүлээн авч, эрсдэл хариуцагчийн эрсдэлийн үйл ажиллагаа, процесст хяналт тавих, эрсдэлийн шинжилгээнд шаардлагатай мэдээллийг гаргуулж авах, тодруулга хийх үүрэгтэй.
- 4.5.6 Хамгаалалтын 2-р шугамын хяналтыг хэрэгжүүлэх үүрэгтэй.

4.6 Нэгжийн удирдлагын эрх, үүрэг

- 4.6.1 Эрсдэл удирдлагын бодлого, журам, тогтолцоо, соёлын хөтөлбөрийн бүх түвшинд сайжруулах санал өгөх эрхтэй.
- 4.6.2 Нэгжийн удирдлагууд нь өөрийн харьяаны газар, үйлдвэр, хэлтэс, алба, нэгжийн эрсдэл хариуцагч байж, эрсдэлийн бүх үе шатыг хариуцлагатайгаар гүйцэтгэх үүрэгтэй.
- 4.6.3 Ажилтнуудын эрсдэлийн талаарх мэдлэг ойлголт, хариуцлагыг сайжруулах үүрэгтэй.
- 4.6.4 Эрсдэлийн нөхцөл байдлыг байнга хянах үүрэгтэй.
- 4.6.5 Компанийн ЭҮ-н хөтөлбөр, арга хэмжээнд идэвхтэй оролцох үүрэгтэй.
- 4.6.6 Эрсдэлийн шаардлагатай мэдээллийг Эрсдэлийн менежерт бэлтгэн хүргүүлэх, мэдээлэл солилцох гэх мэт ажлын уялдаа холбоог хангаж ажиллах үүрэгтэй.

5. ХАРИУЦЛАГА


5.1 Ажилтан, эрх бүхий албан тушаалтны хариуцлага

5.1.1 Эрсдэлийн удирдлагын бодлогыг зөрчсөн ажилтан, эрх бүхий албан тушаалтанд холбогдох хууль тогтоомж болон “Хөдөлмөрийн дотоод журам”, “Хөдөлмөрийн гэрээ”-ний дагуу зохих хариуцлагыг хүлээлгэнэ.

ТӨГСӨВ.

6. ХАВСРАЛТ

5.1 Хавсралт №1 Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх бүтэц



| | | |
|---|---|------------------------|
|  | ГОВЬ ХК-ИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГО | Дугаар: Б-ТУЗ-02-03 |
|---|---|------------------------|

5.2 Хавсралт №2 Эрсдэлийн түвшин тогтоох матриц

| | | | Үр нөлөө | | | | |
|----------|----------|---|----------|------|------|----|--------|
| | | | Маш бага | Бага | Дунд | Их | Маш их |
| | | | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| Магадлал | Маш их | 5 | 5 | 10 | 15 | 20 | 25 |
| | Их | 4 | 4 | 8 | 12 | 16 | 20 |
| | Дунд | 3 | 3 | 6 | 9 | 12 | 15 |
| | Бага | 2 | 2 | 4 | 6 | 8 | 10 |
| | Маш бага | 1 | 1 | 2 | 3 | 4 | 5 |

5.3 Хавсралт №3 Эрсдэлийг удирдах шийдвэр

| Эрсдэлийн оноо | Эрсдэлийн түвшин | Эрсдэлийн түвшинг ойлгох | Хариуцах удирдлага | Эрсдэлийг удирдах шийдвэр |
|----------------|------------------|--------------------------|------------------------------|---|
| 1-3 | Маш бага, Бага | Хүлээн зөвшөөрөх | Хэлтсийн дарга, Албаны дарга | Хүлээн зөвшөөрч болох эрсдэл, шаардлагатай тохиолдолд бууруулах арга хэмжээ, хяналтыг хэрэгжүүлнэ. |
| 4-10 | Дунд | Анхаарал хандуулах | Газрын захирал | Энэ түвшний эрсдэлийг байнгын хяналтад байлгаж, ноцтой түвшинд шилжихээс урьдчилан сэргийлж, эрсдэлийн түвшинг бууруулах арга хэмжээ авна. |
| 11-19 | Их | Ноцтой | Гүйцэтгэх захирал, ЭУБ | Эрсдэлийн аюултай түвшинд шилжихээс урьдчилан сэргийлж, эрсдэлийн түвшинг бууруулах арга хэмжээ авна. Үлдэгдэл эрсдэлийг удирдах хяналтын арга хэмжээнүүдийг тогтмол хэрэгжүүлнэ. |
| 20-25 | Маш их | Аюултай | ТУЗ | Энэ түвшний эрсдэлээс зайлсхийх, эрсдэлийн тохиолдлын үед эрсдэлийн үр нөлөөг нэн яаралтай бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үлдэгдэл эрсдэлийг удирдах хяналтын арга хэмжээнүүдийг байнга хэрэгжүүлнэ. |